№. 4
x3 – x4

5-9

■ RDF-ийг хэрхэн үйлдвэрлэдэг болон ашигладаг (ашиглах) талаар үзүүлэх.

■ Орон нутгийн нөхцөл, технологи дээр үндэслэн RDF-ийг үйлдвэрлэх боломж болон холбогдох үйлдвэрлэлийн өртөг зардлыг судлах.

■ RDF-ийн эрчим хүчний үнэ цэнэ, ашиглалтаас үүдэн ялгарах хий, түлшний форм гэх мэт асуудлуудыг судлах.

■ RDF-ийг хэрэглээнд оруулснаар нүүрсний ашиглалтын хэмжээг хэр бууруулах боломжтойг тооцох.

■ RDF болон нүүрсийг хольж хэрэглэхэд ямар харьцаатай байх болохыг судлан тогтоох.

■ Холбогдох өртөг зардлын тооцооны мэдээг цуглуулах.

2) Ажлын хүрээ

Туршилтын төслийг ажлыг дараах байдлаар зохицуулах болно.

Төслийн хэрэгжилтийн явц

а) Одоогоор дахин ашиглах боломжгүй байгаа чанар муу цаасан болон хуванцар хог хаягдлыг цуглуулна.

б) Энэхүү хог хаягдал RDF үйлдвэрлэх түүхий эд болно.

в) RDF-ийг дулааны станц руу тээвэрлэнэ.

г) RDF-ийг дулааны станцын зууханд шатааж, дүн шинжилгээ хийж холбогдох мэдээг цуглуулна.

Байгаль орчны асуудлууд

RDF-ийг шатаахтай холбогдуулан дараах байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийг авах болно.

а) Монгол Улсад диоксины талаар судалгаа, шинжилгээ хийж буй ШУТИС-ийн Япон профессор Кэмо Ёшимакийг оролцуулах.

б) Туршилтын үеэр шатаах RDF-ийн хэмжээг багасгах.

в) Байгаль орчинд аль болох халгүй станцыг сонгох. Туршилтын төслөөр ашиглах станцад дараах шаардлагууд тавигдана.

■ Зуухны үйл ажиллагааг мэдэх чадварлаг болсон хүчинтэй байх.

■ Уурын зуух нь өөрийн эзэмшлийн зай, талбай ихтэй байх.

■ Цөөн тооны зуухнуудтай байх.

■ Зайдуу байрлах.

■ Хөөс боломжтой бол нүүрс хуттах хийх болон үнс зайлуулах механик эсвэл хагас механик системтэй байх.

■ Зуух нь шаталтын болон халуун усны хэмийн хяналтын самбартай байх.

■ Хэрэглэлтийн санстай байх.

■ Яндан нь хангалттай өндөр байх. Ашигласан хийг гаргах системтэй. 24 цагийн тасралтгүй ажиллагаатай.



Зураг 2:RDF түлшний жишээ

(3) Дахин ашиглаж болох хог хаягдлыг ариун цэврийн цаасаар сольж авах Хэдэлгээнт Хог хаягдал цуглуулах "чиригами кокан" систем

Судалгааны хүрээнд хамрагдсан дүүргүүдийн төлөвлөгөөт бусийн иргэд дахин ашиглаж болох хог хаягдал ихээр гаргадаг боловч одоогоор дахин ашиглах үйл ажиллагаа идэвхтэй явагддаггүй байна. Хог хаягдлыг хог түүгч нар хогийн төвлөрсөн цэг болон орон сууцны хороолол дунд дахин ашиглах ажлыг хийж байна. Хогийн цэг дээр ажиллаж байгаа хог түүгч нар хөрсөөр дарж булах үйл ажиллагаанд саад болохын сацуу орон сууцны хороолол дунд хог түүгч нар орчныг бохирдуулан хог хаягдлыг задгай, замбараагүй тараадаг тул хог хаягдал ялгах, материал болгон сэргээх ажлыг үйлдэн байгуулалтанд оруулах нь чухал байна.

Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь дахиж сэргээх үйл ажиллагааг идэвхжүүлэхийн тулд иргэдэд хог хаягдал бүгд түүхий эд хүлээн авах цэгүүдийг сурталчлах нь зүйтэй. Мастер төлөвлөгөөний төслийн хүрээнд Японд өргөнөөр ашиглагдаж байсан "чиригами кокан" гэдэг хог хаягдлыг дахин ашиглах системийг санал болгож байна. "Чиригами кокан" систем нь ходоггоонт хог хаягдал цуглуулах систем тул хог хаягдал хүлээн авах цэгийн ажилтан орон сууцны иргэд, бизнестэй шууд харьцаж дахин ашиглаж болох хог хаягдлыг ариун цэврийн цаасаар сольж авдаг.

1) Зорилго

Туршилтын төслийн гол зорилгууд:

■ энэхүү систем хэрхэн ажилладаг талаар туршилтын төсөл хэрэгжүүлж үзүүлэх бөгөөд Чиригами кокан систем нь судалгаанд хамрагдсан дүүргүүдэд тохирох эсэхийг судалж шалгах.

■ туршилтын төслийн үеэр RDF-ийн төсөлд ашиглах хог хаягдал цуглуулах.

2) Ажлын хүрээ

Туршилтын төслийг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

■ Их хэмжээний дахин ашиглаж болох хог хаягдал гаргадаг төлөвлөгөөт бусийн орон сууцны хороололд төсөл хэрэгжүүлэх.

■ Чиригами кокан системээр зориулж хуванцар болон цаасан хог хаягдлаа ялгаж байх тухай танилцуулга иргэдэд урьдчилан тараах.

■ Тодорхой хэдэн сурагчийн туршилтын Баасан Ням гаригуудад төсөл хэрэгжүүлэх бөгөөд иргэн хог хаягдлаа дахин ашиглаж болох хог хаягдлыг ариун цэврийн цаасаар сольж авах.

■ Чанар сайтай дахин ашиглах болох хог хаягдлыг зүүчлан борлуулагч нарт худалдах.

■ Чанар муутай дахин ашиглах болох хог хаягдлыг RDF-ийн түүхий эд үйлдвэрлэх зорилгоор ашиглах.

■ Хувийн хэвшлийн оролцоог дэмжих.

(4) Хүнд жингийн хог хаягдлыг өргөж ачих тоног төхөөрөмжийг судлах

Гэр хорооллын иргэд өөрийн үнэрлэлд их хэмжээний үнс гаргадаг тул эдгээр төрлийн хог хаягдал жингийн хувьд хүнд байдаг. Үүнээр хог хаягдал ачиж цуглуулах ажил хүндрэлтэй хугацааны хувьд сунжирч удаашрдаг.

М/Т-ний төслийн хүрээнд дээрх төрлийн хог хаягдлыг хялбаршуулахад тавагтай байдаг гэр хорооллын жин ихтэй хог хаягдлыг өргөж ачих тоног төхөөрөмжтэй самосвал ажиллуулах санал дэвшүүлж байна. Ачиж цуглуулах автомашины асуудлыг шийдвэрлэхгүй бол хог хаягдлыг ачиж цуглуулах үйлчилгээний үр ашгийг дээшлүүлэх боломжгүй юм.

1) Зорилго

Туршилтын төслийн зорилго нь жин ихтэй хог хаягдлыг өргөж ачих энгийн хялбар шийдэл олоход оршино.

2) Төслийн ажлын хүрээ

Туршилтын төслийг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

■ Өргөж ачих төхөөрөмжүүдийн дизайн зургийг боловсруулах.

■ Төхөөрөмжүүдийг ТҮК-ийн самосвалын тэвшинд бэхлэх. ТҮК тухайн төхөөрөмжүүдийг ашиглан хэрэглэж болох эсэх талаар дүгнэлт гаргах.

■ Ашиглахад хамгийн боломжтой төхөөрөмжийг сонгох.

Ашиглах боломжтой төхөөрөмжийн жишээг Зураг 3-т үзүүлэв.

(5) Хог хаягдлын асуудлаар иргэдийн мэдлэг, ухамсрыг дээшлүүлэх

Шаардлага хангахгүй хатуу хог хаягдлын менежментээс болж Улаан Чулуутын хүрээлэн буй орчин ихээр бохирдож улмаар иргэдийн амьдарч буй орчинг ихээр бохирдуулж байгаа талаар иргэд өөрсдөө сайн ойлголттой болсон байгаа нь ажиглагдаж байна. Бас нэг байгаль орчинг бохирдуулж буй асуудал бол хууль бус хог хаях явдал. Зарим хувийн компаниудын машин хогийн цэг хүрэх замдаа хогоо асгаж хаядаг байна. Нөгөөтэйгүүр, хог хаягдал хураах үйлчилгээний чанар муу, хог хаягдлын хураамж өндөр байдаг тул иргэд өөрсдөө хууль бусаар гудамж талбайд хогоо хаяж байгаль орчныг бохирдуулж байна.

Туршилтын төслүүдийн хүрээнд Улаан Чулуутын хогийн төвлөрсөн цэгийн нөхцлийг сайжруулах төсөл хэрэгжүүлэх нь өнөөгийн тухайн орчинд тулгамдаж буй байгаль орчны асуудлуудыг шийдвэрлэхийн сацуу хог хаягдлын менежментийн талаар иргэдийн хандлагыг



Зураг 3: Ачих төхөөрөмжийн жишээ

ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх боломж олгох тэдгээрийн хамтын ажиллагаа, оролцоог нэмэгдүүлэх ач холбогдолтой юм.

1) Зорилго

Туршилтын төсөл хоёр үндсэн зорилготой:

■ Иргэдийн оролцоотой хяналтын систем нэвтрүүлж хогийн цэгийн найдвартай үйл ажиллагааг хангах

■ Олон нийтийн хамтын ажиллагааны дэмжлэгтэйгээр хууль бус хог хаях явдлыг багасгах

2) Ажлын хүрээ

Туршилтын төсөл хоёр бүрэлдэхүүн хэсэгтэй. Үүнд, (1) иргэдийн оролцоотой хяналтын систем нэвтрүүлэх болон (2) хууль бус хог хаягдлыг таслан зогсоох кампанит ажил зохион байгуулах.

Иргэдийн оролцоотой байнгын ажиллагаатай хяналтын систем байгуулах

Улаан Чулуутын хогийн цэгийн орчимд явуулсан байгаль орчны судалгааны дүнд иргэд тулгамдаж буй асуудлуудын талаар ойлголттой байгаа нь ажиглагдсан бөгөөд зарим иргэд дээрх асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх талаар санал гаргаж байв. Нөгөөтэйгүүр, иргэд хатуу хог хаягдлын менежментийн талаар мэдлэг дутуу байгаа нь ажиглагдсан бөгөөд хатуу хог хаягдлын менежментийн талаар иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх, ойлголтыг гүнзгийрүүлэх зорилгоор туршилтын төслийн эхний үе шатны хүрээнд сургалт, хүмүүжлийн ажилд онцгойлон хандуулах болно.

Туршилтын төслийг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

■ Мониторингийн хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулах. Үүнд, 4-р хорооны Засаг дарга, байгаль орчны асуудал хариуцсан Хотын захиргааны ажилтан, байгаль орчин/бохирдолтын асуудал хариуцсан байцаагч, өрхийн эмнэлгийн ажилтан, сургуулийн багш, иргэдийн төлөөлөгч, хорооны ТББ-ын гишүүн зэрэг болно.

■ Сургалт, хүмүүжил болон кампанит ажил зохион байгуулахад шаардагдах материалыг бэлтгэх.

■ Хатуу хог хаягдлын менежментийн асуудлаар иргэдийн мэдлэг, ойлголтыг гүнзгийрүүлэх зорилгоор сурталчилгааны плакат, танилцуулга зэрэг материалуудыг бэлтгэх.

■ Байнгын мониторингийн ажлыг эхлүүлэх.

■ Мониторингийн ажлын дүн нэгтгэх болгох тогтолцоо байгуулах.

Гурван сард нэг удаа мониторинг зохион байгуулах ба мониторингийн үеэр дараах зүйлүүдийг шалгах:

■ Байгаль орчинд нөлөөлөх байдал: гал ба утаа, эвгүй үнэр, бохир шингэн, хог хаягдлын тархалт, амьтан (нохой, шувуу гэх мэт), хортон шавьж (ялаа, өт гэх мэт), гадна байдал

■ Үйл ажиллагааны нөхцөл: хог түүгч нарын ажлын нөхцөл, хүнд даацын машин механизм (хогны машин ба бульдозер), хог хаягдлын овоолго

■ Байгууламжуудын хэвийн үйл ажиллагааны байдал: автозогсоол, хогийн цэг доторх зам (гол зам), хогийн цэг доторх зам (туслах зам), ажлын талбар, гүүрэвчин зам, хог хаягдлыг хийсч тархахаас сэргийлэх хөдөлгөөнт хашаа, хий зайлуулах байгууламж, аюулгүй байдлыг хангах байгууламж, хашаа (үл хөдлөх), хаалга, суваг, бохир шингэн цуглуулах байгууламж, бохир шингэн цэвэрлэх байгууламж, бохир усны суваг.

Туршилтын төслийн хэрэгжилтийг иргэдийн оролцоотой хийх үнэлгээ (хэвлэл мэдээллийн төлөөлөгчидэд танилцуулах)

Тухайн хорооны иргэдийн оролцоо, сонирхлыг дэмжих үүднээс 20 иргэдийг хогийн цэгийн нөхцлийг сайжруулах туршилтын төсөл хэрэгжүүлэхээс өмнө анхны хяналтын ажилд оролцуулах болно. Төсөл хэрэгжиж дууссаны дараа эдгээр иргэд хяналтын комиссын гишүүдтэй хамтран төслийн үйл ажиллагаанд үнэлгээ өгөх үүднээс хоёрдахь хяналтын ажилд оролцох болно.

Иргэдийн оролцоотой хийсэн үнэлгээний дүнг мэдээллийн тоймд хэвлэн хорооны иргэдэд тараах ба төслийн вэб хуудсаар сурталчлах болно.

Хууль бус хог хаях явдлыг таслан зогсоох кампанит ажил

Улаан Чулуутын орчимд хоёр төрлийн хууль бус хог хаях явдал байна. Үүнд, хогийн цэг рүү нэвтрэх замын хажуугаар хаясан хог хаягдал ачих машинуудын хууль бус хог хаягдал болон хорооны нутаг дэвсгэрт хаясан иргэдийн хууль бус хог хаягдал. Энэхүү хоёр асуудлыг тус тусад нь хандаж шийдвэрлэх арга замыг хайх шаардлагатай.

Хувийн хогны машинуудыг хянах зорилгоор 4 дүгээр хорооны Засаг дарга одоогоос тодорхой арга хэмжээ авч цагдаагийн постыг хамгийн их хууль бусаар хог хаядаг газар байгуулахаар төлөвлөж байна. Энэхүү санаачилгыг төслийн бүрэлдэхүүн хэсэг болгох нь чухал бөгөөд хууль бус хог хаягдлын мониторингийн ажлыг иргэдээр гүйцэтгүүлэх нь нэн чухал.

Хууль бус хог хаягдлыг цэвэрлэх томоохон ажлыг зохион байгуулж улмаар иргэд болон хогны машины жолооч нарын мэдлэг, ухамсрыг дээшлүүлэх зорилготой.

Хорооны иргэд өөрсдөө хууль бус хог хаях явдал нь хог хаягдал ачиж цуглуулах үйлчилгээний чанар муу, хураамж нь өндөр болон мэдлэг, ухамсар доогуур байгаатай холбоотой байж болно. Иргэдийг хууль бусаар хог хаях явдлыг бууруулахын тулд хог хаягдал цуглуулах үйлчилгээг сайжруулах шаардлагатай боловч туршилтын төслийн хүрээнд тэрхүү ажлыг хамрах боломжгүй тул иргэд, засаг захиргаа болон хог хаягдал цуглуулах талууд хамтран тодорхой арга хэмжээнүүд авах болно.

Энэхүү төслийг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

■ ЗАА, 4-р хороо, иргэдийн төлөөлөгчид, хог хаягдал ачих үйлчилгээний төлөөлөл, хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг ТББ-ын төлөөлөл болон ЖАЙКА-ийн судалгааны багаас бүрдсэн ажлын хэсэг байгуулах

■ Иргэдийн уулзалтуудыг зохион байгуулах

■ Сургалт, хүмүүжил болон кампанит ажил зохион байгуулахад шаардагдах материалыг бэлтгэх

■ Цэвэрлэх ажлуудыг зохион байгуулах

2. Нэмэлт агуулга

Манай судалгааны баг судалгааны хоёрдугаар үе шатыг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд зарим туршилтын төслүүдийн хэрэгжилтийг эхлүүлж зарим төслүүдийн төлөвлөлтийг хийж байна. Туршилтын төслүүдийн явц болон үр дүнг цаашид танд бид цаг тухайд нь мэдэгдэж байх болно.

Түүнчлэн судалгааны баг шинэ хогийн төвлөрсөн цэг байгуулах техник, эдийн засгийн үндэслэл, төсөл хийнэ. Хотын захиргаа тус цэгийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг гүйцэтгэнэ. Үүнтэй холбогдуулан олон нийтэд хүргэх мэдээллийн уулзалтыг зохион байгуулж тэдгээр уулзалтуудын дүнг мэдээллийн тоймоор уншигч танд хүргүүлэх болно.

Монгол Улсын Улаанбаатар хотын
Хуурай хог хаягдлын менежментийн
судалгааны төсөл
ЖАЙКА-гийн судалгааны баг

Монгол Улс, Улаанбаатар-48,
Чингэлтэй дүүрэг, Бага тойруу гудамж,
Нийслэлийн Төр Захиргааны III байр
1203 тоот өрөө
Утас: 976-11-327128
Факс: 976-11-323128
И-мэйл: swm@skycc.mn
http://www.kkcub.mn/